

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
НАЙМДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.08.03-2020.08.31/

2020 оны 08 дугаар сарын 31

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд “Монгол Улсын Виз олгох журам”-ын 6.2-т заасны дагуу ачаа тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Таван толгой транс” ХХК-ийн 40, “Божманайзууд” ХХК –ийн 2, нийт БНХАУ-ын 42 иргэний визийн сунгалтын материалыг бүрдүүлэн төв газарт хүргүүлж, холбогдох дансанд тэмдэгтийн хураамжийн 4.611.600 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Тус газарт шинээр баригдах барилгын ажил 08 дугаар сарын 14-ний өдрөөс эхэлж, гүйцэтгэгчээр “Престектив актив констракшн” ХХК ажиллаж байна.

Албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг гарган Захиргаа, удирдлагын газарт 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлэн ажилласан.

1.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-0
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-0/
- Явуулсан бичиг /албан тоот-11/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг- 4
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

1.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 08 дугаар сард 38,101,500 төгрөгийн санхүүжилт авч нийт 21 албан хаагчийн цалинд 21,631,281.87 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 2,712,036.37 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,340,900 төгрөг, хангамж, бараа материалын зардалд

754,398.43 төгрөгийн гүйлгээг Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан хийж ажилласан байна.

Тус газрын 2020 оны 07 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг хуульд заасан хугацаанд холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

1.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 1 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Бүсийн газарт шинээр баригдах барилгад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн.

Хоёр. Бусад

2.1 Шинэ коронавирусын /ковид-19/ дэгдэлттэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор халуун чацаргана, витамин, гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна.

Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.